



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

Дугаар: 2011/06

Огноо: 2011 оны 6 дугаар сарын 22

Эмбарго: 2010 оны 6-р сарын 23-ний Пүрэв гаригийн 11:00 цаг хүртэл

Монголбанкны Захирлуудын зөвлөлийн 2011 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн хурлаас бодлогын хүүг өөрчлөлгүй 11.5 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа. Үндэсний Статистикийн хорооны 2011 оны 5 дугаар сарын мэдээгээр улсын хэмжээнд тооцсон ХҮИ жилийн 4.2 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд тооцсон ХҮИ жилийн 2.8 хувьд хүрээд байна. Жилийн инфляци сүүлийн 4 сарын туршид 12 нэгж хувиар буурч 1 оронтой тоогоор илэрхийлэгдэж байгаа хэдий ч энэ хандлага цаашид үргэлжлэхээргүй, түр зуурын шинжтэй буюу голчлон махны үнийн өөрчлөлтөөс шалтгаалж байна.

Ирэх саруудад нийлүүлэлтийн болон эрэлтийн шалтгаантай инфляцийн дарамт нэмэгдэхээр байна. Тухайлбал, иргэдэд олгож буй мөнгөн тэтгэмж, батлагдсан төсвийн зарлагын өсөлт болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын нөлөөгөөр хувийн секторын эрэлт нэмэгдэж байгаагаас суурь инфляци энэ оны 3 дугаар сард 7.9 хувь, 4 дүгээр сард 8.9 хувь, 5 дугаар сард 9.8 хувьд тус тус хүрч сүүлийн 3 сарын турш тасралтгүй өслөө.

Мөн шатахууны нийлүүлэлтийн хомсдол, түүний үнийн өсөлтийн дам нөлөө нь бусад бараа, үйлчилгээний үнэд дарамт учруулах тул мөнгөний бодлогын төлөвийг чангаруулах нөхцлийг бүрдүүлж байна. Нийт эрэлтийн өсөлтөөс үүдэлтэй инфляцийн нөлөөг аль болох бага байлгахад Монголбанк сүүлийн 4 сарын турш арга хэмжээ авч ажиллав. Монголбанк инфляцийн цаашдын хандлагыг анхааралтай ажиглаж байгаа бөгөөд шаардлагатай нөхцөлд шийдвэртэй арга хэмжээ авах болно.

МОНГОЛБАНК